

**“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ ЗАР**

Компанийн 2024 оны 3 дугаар сарын 23-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Хаалттай хүрээнд нэмж үнэт цаас гаргах” асуудлыг хэлэлцэж, нийт хувьцаа эзэмшигчдийн 79.77 хувийн саналаар дэмжигдэж шийдвэрлэгдсэн. Уг асуудалд эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрх үүсэж байгаа юм. Иймд уг шаардах эрх үүссэн тухай зарыг хүргэж байна.

Шаардах хуудас авах газар:	Компанийн өөрийн байр болон хувьцаа эзэмшигчдийн үйлчлүүлж буй брокер, дилерийн компаниуд
Компанийн хаяг	Баянгол дүүрэг 2-р хороо Эрхи төв 402 тоот
Шаардах хуудас авах сүүлийн өдөр	2024 оны 5 сарын 6 өдөр
Баримт бичигтэй танилцах:	2024 оны 4 сарын 2-ны өдрөөс 2024 оны 5 сарын 6-ны өдрийн 17:00 цаг хүртэл
Холбоо барих:	info@vik.mn tandeminvest.nbf@gmail.com 70151510, 88008702

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 3 сарын 26 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.4 дэх хэсэг, 53 дугаар зүйлийн 53.4 болон 53.5 дахь хэсэг, 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2, 54.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт болон Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.22-д заасныг үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Компани хаалттай хүрээнд нэмэлт энгийн хувьцаа гаргах болсонтой холбогдуулан компанийн тухай хуулийн 53.4-д заасны дагуу хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлсүгэй
2. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг Хавсралт 1-ээр баталсугай.
3. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх шаардах хуудсыг Хавсралт 2-оор баталсугай.
4. Компанийн эргүүлэн худалдан авах хувьцааны үнийг Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-с 2024 оны 03 сарын 01-ний өдөр авсан сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж үнэ болох 19.79 /Арван есөн төгрөг далан есөн мөнгө/ төгрөгөөр тогтоосугай.
5. Компанийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу хувьцаа эзэмшигчид мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Ганхүлэг)-д үүрэг болгосугай.
6. Энэхүү тогтоол болон журмын хэрэгжилтийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийг холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ж.Ганхүлэг)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

**КОМПАНИ ӨӨРИЙН ГАРГАСАН ХУВЬЦААГ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШААРДЛАГААР ЭРГҮҮЛЭН
ХУДАЛДАЖ АВАХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

НЭГ.Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2024 оны 3 дугаар сарын 23-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Хаалттай хүрээнд нэмж үнэт цаас гаргах” асуудлыг хэлэлцэж, нийт хувьцаа эзэмшигчдийн 79.77 хувийн саналаар дэмжигдэж шийдвэрлэгдсэн. Уг асуудалд эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрх үүсэж байгааг “Компанийн тухай хууль”-ийн 53, 54 дүгээр зүйлийн дагуу зохицуулахад оршино.

**ХОЁР. Шаардах эрхээ хэрэгжүүлэх хувьцаа эзэмшигчдийн
шаардлагыг хүлээн авах, бүртгэх**

- 2.1.Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалтыг уг шаардах эрх үүссэн өдөр буюу компанийн 2024 оны 3-р сарын 23-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд байсан мэдээллийг үндэслэн бүртгэнэ.
- 2.2.Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь эргүүлж авах тухай шаардлагыг компанийн байранд эсвэл харилцаг брокер дилерийн компаниар дамжуулан бичгээр гаргана.
- 2.3.Уг эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь эргүүлэн худалдан авах тухай шаардлагыг уг шаардах эрх үүссэн тухай олон нийтэд мэдээлснээс хойш ажлын 30 өдрийн дотор компанид ирүүлнэ.

ГУРАВ. Шаардах эрхийг хэрэгжүүлэх

- 3.1.Компаниас хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх үүсгэсэн шийдвэр гарснаас хойш энэ эрх, түүнийг хэрэгжүүлэх журмын талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.
- 3.2. Хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх хугацаа, худалдан авах үнэ, нөхцөл зэргийг Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.
- 3.3. Компани дараах үндэслэлээр хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдах тухай шаардлагад татгалзсан хариу хүргүүлэх эрхтэй.
Үүнд:
 - 3.3.1. Хувьцаагаа эргүүлэн худалдах тухай шаардлага нь компанийн тухай хууль болон энэ журамд заасан шаардлагыг хангаагүй,

- 3.3.2. Хувьцаа эзэмшигч төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон үнээс илүү үнээр хувьцаагаа худалдахыг санал болгосон,
- 3.3.3. Энэ журмын 2.1-т заасан жагсаалтад бүртгэлгүй бол,
- 3.3.4. ҮЦТХТ дэх хувьцааны дансанд хувьцаа эзэмшил бүртгэлгүй бол,
- 3.4. Хувьцаа эргүүлэн худалдан авахтай холбоотой төлбөр тооцоог ҮЦТХТ-ээр дамжуулан хийж гүйцэтгэнэ.
- 3.5. Компани шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчээс бичгээр авах маягтад овог, нэр, эргүүлэн худалдаж авахыг шаардаж байгаа хувьцааны тоо, төрөл зэргийг тусгаж нэмэлтээр иргэний үнэмлэхийн хуулбарыг авна.

ДӨРӨВ. Шаардах эрхийг дуусгавар болгох

- 4.1. ҮЦТХТ дээрх хувьцаа эзэмшигчдийн дансанд төлбөр тооцоо бүрэн хийгдсэн тухай тайланг хүлээн авч Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлснээр дуусгавар болно.

ТАВ. Бусад

- 5.1 Эрх бүхий хувьцаа эзэмшигч нь шаардах эрхийг хэрэгжүүлэх журамтай холбоотой зөвлөгөө, зааварчилгааг компаниас авах эрхтэй.
- 5.2 Компани энэ журмын 3.3-д заасны дагуу хувьцаагаа эргүүлэн худалдан авахаас татгалзсан, эсхүл ТУЗ-өөс тогтоосон зах зээлийн үнийг бодитой бус гэж үзвэл хувьцаа эзэмшигч нь энэ талаарх гомдлоо уг шийдвэр гарснаас хойш гурван сарын дотор шүүхэд гаргах эрхтэй.

**“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ
ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН АВАХЫГ
КОМПАНИАС ШААРДАХ ХУУДАС**

“Тандэм Инвэст ББСБ” ХК-ийн 2024 оны 3-р сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэрт эсрэг саналтай болон санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүссэний дагуу өөрийн эзэмшлийн 100 хувийн хувьцаа болох ширхэг хувьцааг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон үнэ болох 19.79 төгрөгөөр эргүүлэн авахыг шаардаж байна.

Хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчийн тухай мэдээлэл:

Хувьцаа эзэмшигчийн овог нэр: овогтой

Регистрийн дугаар:

Оршин суугаа хаяг:

Холбоо барих утас:

ҮЦТХ дахь дансны дугаар:

Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо ширхэг:

Гарын үсэг:

Хүсэлт гаргасан огноо:

Хүлээн авсан брокер, дилерийн компани:

Компанийн нэр:

Хүсэлтийг хүлээн авсан огноо:

Хүсэлт хүлээн авсан: “.....” ХХК-ийн ажилтан

Тамга

Хүсэлт хүлээн авсан: “Тандэм Инвэст ББСБ” ХК

Ажилтны овог нэр: овогтой

Гарын үсэг

Тамга

“ҮЦТХТ” ХХК

ҮЦТХТ-д хүлээн авсан огноо:

Хүсэлт хүлээн авсан ХӨЭБКА-ны ажилтан:

Гүйлгээ хийсэн ХӨЭБКА-ны ажилтан:

Хянасан ХӨЭБКА-ны захирал:

Тамга